



ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ ОНӨААТҮГ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Коронавируст (КОВИД-19) халдвараас
урьдчилан сэргийлэх байгууллагын дотоод үйл ажиллагаанд
мөрдөх түр журам батлах тухай

Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.4, 1.10 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/06 дугаар захирамж, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх түр журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Халдвараас урьдчилан сэргийлэх түр журмын дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий инженер, Техникийн хэлтэс /Б.Энхцаг/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч захирал /Б.Даваасүрэн/-д үүрэг болгосугай.



“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын
Захирлын 20.4-оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Коронавируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх түр журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь “Коронавируст /COVID-19/ урьдчилан сэргийлэх, Улсын “Онцгой комисс”-оос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг доголдолгүй явуулах, ажилтнуудыг цэвэр орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагад халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээг зохицуулахад оршино.

Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

2.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг үйлчилгээний танхим, албан тасалгаа, явган шат, ариун цэврийн өрөө зэрэгт байршуулах

2.2. Халдваргүйжүүлэх бодис, амны хаалт, нүүрний хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис, гарын шингэн саван, гарын цаасан алчуур, цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлэх

2.3. Ажилчдын ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж гарын шингэн саван, халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах

2.4. Ажлын байранд эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл, амны хаалт, нэг удаагийн хамгаалах хувцас, гар халдваргүйжүүлэгч, бээлий, хог хаягдлын уут зэрэг хэрэгслээр хангасан ТУСГААРЛАХ ӨРӨӨ гаргаж бэлтгэх

2.5. Коронавируст халдвар /COVID-19/-ын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах 2-3 ажилтныг томилох

2.6. Ажилчдын биеийн халууныг үзэж тэмдэглэх, өвчний шинж тэмдэг илэрвэл /биеийн халуун 37.1 хэмээс дээш/ баазын эмч нар бүртгэл хийж эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөх

2.7. Амны хаалт, хамгаалалтын бээлийгүй иргэдийг байгууллагад нэвтрүүлэхгүй байх

2.8. Ажлын байранд ажилтнууд амны хаалт, нүүрний хаалтыг заавал зүүж хэрэглэх, /үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд нэг удаагийн бээлий, малгайг тогтмол зүүж ажиллах/ гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлэх, бусадтай гар барихгүй байх

2.9. Ажилтан үйлчлүүлэгчтэй 1.5м-2 метр зай барих

2.10. Халдвар авах эрсдэл бүхий ажлын байранд ажиллаж буй ажилтнууд хамгаалалтын хувцас хэрэглэлийг зааврын дагуу хэрэглэх

2.11. Үйлчилгээг цахимжуулан хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх

2.12. Хүнсний аюулгүй байдлыг өндөр төвшинд анхаарч өдрийн хоолыг хүний бөөгнөрөл үүсгэлгүй, нэг удаагийн савлагаатай авч хэрэглэх

2.13. Ажилтан бүр өөрийн эрүүл мэнд, дархлааг дэмжихэд анхаарах, эрүүл мэндийн байгууллагын өгч буй санамж зөвлөгөөг дагаж хэрэгжүүлэх

Гурав. Цэвэрлэгээ, ариутгал

- 3.1. Өрөө тасалгаанд 2 цаг тутам 10-15 минут агаар сэлгэлт хийх
- 3.2. Салхивчгүй өрөө тасалгаанд өдөрт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх
- 3.3. Барилга байгууламж, гаднах орчны талбайг ЭМ-ийн байгууллагын зөвлөгөөний дагуу өөрсдийн нөөц бололцоогоор ариутгах
- 3.4. Өдөр бүр цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, хаалганы бариул, цахилгаан шатны товчлуур, унтраалга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргуу зэрэг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутам халдваргүйжүүлэх бодисын уусмалаар / 1 л усанд 15мл белизна, жавилин / шүршиж, арчиж халдваргүйжүүлэх.
- 3.5. Ажилтнууд өөрийн ажлын ширээ сандал, компьютер, шүүгээ зэрэг албан тасалгаанд буй хүний гар хүрэх гадаргууг 2 цаг тутамд чийгтэй алчуураар арчих, халдваргүйжүүлэх
- 3.6. Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувийн багаж хэрэгслийг цэвэрлэж халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар зайлж хатааж хадгалах
- 3.7. Нийт ажилтнууд хувийн ариун цэврийг сайтар сахих, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөг зүй зохистой ашиглах, гарын саван, ариун цэврийн цаасыг зохистой хэрэглэж ил задгай нус, цэр, шүлсээ хаяхгүй байх
- 3.8. Нийтийн тээврийн үйлчилгээнд гарч байгаа тээврийн хэрэгслүүдэд 14 хоног тутам мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжилт хийлгэх
- 3.9. Оройн буултаар ирж байгаа тээврийн хэрэгслүүдэд ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийлгэж гүйцэтгэлд нь байнга хяналт тавих

Дөрөв. Халдварт өвчний шинж тэмдэг илэрвэл анхаарах зүйлс

4.1. Сүүлийн 14 хоногийн хугацаанд онош батлагдсан хүнтэй ойрын хавьтал болсон, халуурах, хуурай ханиалгах, ядарч сульдах, цэр гарах, амьсгал давчдах, булчин, хоолой, толгой өвдөх, суулгах, хамар битүүрэх зэрэг шинж тэмдгийн аль нэг нь илэрсэн хүнийг сэжигтэй тохиолдол гэж үзэх

4.2. Ажилтан ажлаа хийж байх явцад дээрх сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл:

4.2.1. Сэжигтэй тохиолдлын мэдээлэл авмагц томилогдсон ажилтан тусгаарлах өрөөнөөс амны хаалт, нэг удаагийн хамгаалах хувцас, бээлий, улавч өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх

2.2. Хүний нөөцийн ажилтан удирдлагад мэдээлж, эрүүл мэндийн байгууллага /ХӨСҮТ 119, 88086829/-д дуудлага өгөх

4.2.3. Сэжигтэй тохиолдолтой 15 минутын турш 1 метрээс дотогш зайд харьцсан хүнийг ойрын хавьтал гэж үзэх ба ХӨСҮТ-ийн тандалт судалгааны баг иртэл ойрын хавьтлыг ажлын өрөөнд нь буюу тусгаарлах өрөөнд тусгаарлана.

4.2.4. Сэжигтэй тохиолдлын шинжилгээний хариу гартал тусгаарлах өрөөг битүүмжилж эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагана.

4.2.5. Сэжигтэй тохиолдлын онош батлагдсан тохиолдолд голомтот Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэгдсэн халдваргүйжүүлэлтийн баг ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх

4.2.6. Нийт ажилтнууд айж сандралгүй, тайван байж дүрэм журмыг баримталж ажиллах

4.3. Ажилтан гэртээ байх үед болон ажилтны гэр бүлийн гишүүнд сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл:

4.3.1. Ажилтан гэртээ байх хугацаанд өөрт эсвэл гэр бүлийн гишүүнд 4.1-д дурдсан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдах ажилтан болон эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж ажилдаа ирэлгүй гэртээ тусгаарлах арга хэмжээ авах

4.3.2. Гэрийн тусгаарлалтад байгаа сэжигтэй тохиолдол нь гэрээсээ гарахгүй, гэртээ зочин урихгүй байж гэр бүлийн бусад гишүүдээс аль болох зай барихыг хичээж, хоол хүнс, ахуйн хэрэглээний зүйлс, аяга тавгийг тусдаа хэрэглэх, өдөрт 3 удаа халуунаа хэмжиж эрүүл мэндийн хяналтын хуудас бөглөх, харьяа өрхийн эмчид мэдэгдэх зэрэг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг баримтлах

4.3.3. Эрүүл мэндийн асуудлаар харьяа дүүргийн өрхийн эмнэлэг болон 119, 100, 103, 80086829 дугаарт хандаж зөвлөгөө авах

Тав. Ажлын горим, ажлын цагийн зохицуулалт

5.1. Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэр, тогтоосон хөл хорионд үндэслэн тухай бүр гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрээр ажлын цаг, ажиллах горимыг тогтооно. Үүнд доорх арга хэмжээг тушаалаар шийдвэрлэх

5.1.1 Ажлын цагийг богиносгох

5.1.2 Ажлын уян хатан цагийн хуваарилалт хийх

5.1.3 Гэрээс буюу зайнаас цахимаар ажиллах зохицуулалт хийх

5.1.4 Сул зогсолт хийх

Зургаа. Ажилтны үүрэг хариуцлага

6.1. Энэ журамд заасан ажлын байранд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, цэвэрлэгээ ариутгалын заавар, бусад заалтууд болон эрүүл мэндийн байгууллагаас иргэнд зориулж гаргасан заавар зөвлөмжийг сайтар дагаж мөрдөх

6.2. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиал орчны худал мэдээллийг бусдад түгээх, сөрөг мэдээллээр бусад ажилтнуудын сэтгэл зүйд нөлөөлөхгүй байх

6.3. Өөрийн явсан зам маршрут, уулзсан хүний тухай өдөр бүр хувийн тэмдэглэл хөтлөх

6.4. Захирлын тушаалаар ажлын цаг, ажиллах горимд өөрчлөлт орсон тохиолдолд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах

6.5. Ажил үүргээ гэрээсээ гүйцэтгэх тушаал шийдвэр гарсан тохиолдолд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, өдөр бүр ажлын явц, үр дүнг шууд удирдлагад тайлагнах, шаардлагатай тохиолдолд ажлын байранд ирж ажиллах, оршин суугаа газраас өөр тийшээ явахгүй байх, гар утсаа нээлттэй байлгах

Долоо. Бусад

7.1. Энэхүү журам нь улс орон, бүс нутгийн хэмжээнд зарласан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Журамд Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос гаргасан тогтоол шийдвэрт үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын
Захирлын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн
А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ” ОНӨААТҮГ-ААС КОРОНАВИРУСТ /КОВИД-19/ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТҮР ЖУРМЫН ДАГУУ
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Төлөвлөгөөний зорилго: “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт” шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн онцгой комисс, Нийтийн тээврийн үйлчилгээний газруудаас ирсэн тогтоол, захирамж, зөвлөмжүүдийг удирдлага болгон Коронавируст /Ковид-19/-ээс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулахад оршино.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдэх ажлууд	Авах арга хэмжээ	Хариуцах хэлтэс, албад	Хяналт тавих хэлтэс, албад
1	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг хүний нүдэнд харагдахуйц ил газар байршуулах	Хурлын танхим, албан тасалгаа, явган шат, ариун цэврийн өрөө	ХАБЭААлба	ДХШХ, ХАБЭААлба
		1.2. Халдваргүйжүүлэх бодис, халдваргүйжүүлэх цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлэх	Нэг удаагийн хамгаалах хувцас, амны хаалт, нүүрний хаалт, бээлий, гарын шингэн саван,	ХАБЭААлба, СБХ	ДХШХ, ХАБЭААлба
		1.3. Ажилчдын ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж гарын шингэн саван, халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулах	Тухайн өрөө тасалгаа хариуцсан үйлчлэгч нар	ЗУХ	ДХШХ, ХАБЭААлба
		1.4. Ажлын байранд эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл хэрэгслээр хангасан ТУСГААРЛАХ ӨРӨӨ гаргаж бэлтгэх	Амны хаалт, нэг удаагийн хамгаалах хувцас, гар халдваргүйжүүлэгч, бээлий, хог хаягдлын уут	ХАБЭААлба, ЗУХ	ДХШХ, ХАБЭААлба
		1.5. Коронавируст халдвар /COVID-19/-ын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах 2-3 ажилтныг томилох	1. Эмч 2. ХАБЭАлба 3. Тухайн өдөр ээлжид гарч буй ээлжийн инженер, шалгах механик нар	ЗУХ	ДХШХ, ХАБЭААлба
		1.6. Ажилчдын биеийн халууныг үзэж тэмдэглэл хөтлөх, өвчний шинж тэмдэг илэрвэл /биеийн халуун 37.1 хэмээс дээш/ байгууллагын удирдлагад шуурхай мэдэгдэх/ бүртгэл хөтөлж тусгаарлах өрөөнд оруулах арга хэмжээ авах/	Эрүүл мэндийн байгууллага, НОК-т яаралтай мэдэгдэх	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба

2	Цэвэрлэгээ ариутгалын талаар	1.7.Амны хаалт, хамгаалах бээлийгүй иргэдийг байгууллагад нэвтрүүлэхгүй байх	Орох, гарах иргэдэд тавих хяналтыг сайжруулах	ТХ, гэрээт харуул хамгаалалтын алба	ДХШХ, ХАБЭААлба
		1.8.Ажлын байранд ажилтнууд амны хаалт, нүүрний хаалтыг заавал зүүх, бээлий хэрэглэх халдваргүйжүүлэх бодисоор ариутгах бусадтай гар барихгүй байх	Ажилтан бүр хэвшил болгох	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		1.9.Ажилтан үйлчлүүлэгчтэй харьцахдаа хоорондын зайг барих	Хоорондын зайг 1,5м-2м зайг барьж харьцах	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		1.10.Халдвар авах эрсдэл бүхий ажлын байранд ажиллаж буй ажилтнууд хамгаалалтын хувцас хэрэглэлийг зааврын дагуу хэрэглэх	1.Ээлжийн инженер 2.Шалгах механик 3.Тэрэг тавигч 4.Ариутгал хийж буй шалгагч нар	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		1.11.Хүнсний аюулгүй байдлыг өндөр төвшинд тавьж хяналтыг сайжруулах	Цайны газруудыг өдөр тутам ариутгал цэвэрлэгээ хийлгэж нэг удаагийн аяга, таваг, халбага сэрээ хэрэглүүлэх	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		2.1.Ажилчид өрөө тасалгаандаа өдөр бүр 2 цаг тутам 10-15 минут агаар сэлгэлт хийх, чийгтэй алчуураар цэвэрлэгээ хийж байх	Өдрийн болон ээлжийн ажилчид хамрагдана.	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		2.2.Салхивчгүй өрөө тасалгаанд өдөрт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх	Тухайн өрөө тасалгаа хариуцсан үйлчлэгч нар	ЗУХНХ	ДХШХ, ХАБЭААлба
		2.3.Байгууллагын өрөө, тасалгаа, тээврийн хэрэгслүүдэд 14 хоног тутам мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжилт хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийх	СБХ ХАБЭААлба	ДХШХ, ХАБЭААлба
		2.4.Өдөр бүр цэвэрлэгээ халдваргүйжилтийг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутамд халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүршиж, арчиж халдваргүйжүүлэх	Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, унтраалга, цахилгаан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гадаргуу	ЗУХ	ДХШХ, ХАБЭААлба
		2.5.Нийт ажилтнууд хувийн ариун цэврийг сайтар сахих, нийтийн эзэмшлийн тапбайд зүй зохистой байх	Ариун цэврийн өрөөг зүй зохистой ашиглах, ил задгай нус, цэр, шүлсээ хаяхгүй байх	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		2.6.Оройн буултаар ирж байгаа тээврийн хэрэгслүүдэд ариутгал халдваргүйжилтийг тогтмол хийлгэж гүйцэтгэлд хяналт тавих	Хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах	ТҮХ, ЗУХ	ДХШХ, ХАБЭААлба

3	Халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрвэл	3.1.Сэжигтэй тохиолдлын мэдээлэл авмагц удирдлагад мэдээлж, эрүүл мэндийн байгууллага /ХӨСҮТ 119, 88086829/-д дуудлага өгөх	Томилогдсон ажилтан тусгаарлах өрөөнөөс амны хаалт, нэг удаагийн хувцас, бээлий, улавч өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх, байрлуулах	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба
		3.2.Ажилтан гэртээ байх хугацаанд өөрт эсвэл гэр бүлийн гишүүнд шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдах ажилтан болон эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх	Ажилдаа ирэлгүй гэртээ тусгаарлах арга хэмжээ авах, шинжилгээний хариу гартал ажилдаа ирэхгүй байх	ХАБЭААлба, эмч	ДХШХ, ХАБЭААлба

Жич: Дээрх төлөвлөгөөний дагуу хэлтэс, албадууд хариуцсан ажлынхаа тайлан мэдээг хүснэгтийн дагуу бичиж долоо хоног бүрийн нэг дэх өдөр ХАБЭААлбанд бичгээр болон дотуур сүлжээгээр өгнө. Тайлан мэдээг хоцроосон тохиолдолд хариуцлага тооцох болно.